



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2023 оны сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-д дор дурдсан агуулга бүхий 5.4.3 дахь заалтыг нэмсүгэй.

1/ Журмын 5.4.3 дахь заалт;

“5.4.3. Даатгалын зуучлалын үйл ажиллагаандаа хууль, журам болон даатгагчтай хамтран ажиллах гэрээг зөрчсөнөөс үүдэн даатгуулагч эсхүл даатгагч хохирсон бол Хорооноос даатгалын зуучлагчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.”

2. Мөн журмын 3.5 дахь хэсгийн “боловсруулсан” гэсний өмнө “энэ журмын ... дүгээр хавсралтад заасны дагуу” гэж, 3.7 дахь хэсгийн “сар” гэсний өмнө “нэг удаа эсхүл” гэж, 3.11 дэх хэсгийн “хэмжээг” гэсний дараа “Хороонд бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний хураамжийн тооцоололд үндэслэн” гэж, 4.4 дэх хэсгийн “үйл ажиллагаа” гэсний өмнө “зуучлалын” гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын 1, 2, 3 дугаар хавсралтыг энэ тогтоолын хавсралтаар, 2.2 дахь хэсгийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай.

1/ Журмын 2.2 дахь хэсэг;

“2.2. Урт хугацааны даатгагч нь зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалаар энэ журмын ... дүгээр хавсралтад зааснаас бусад аливаа шалтгааны улмаас даатгуулагч нас барах болон хөдөлмөрийн чадвараа 70 буюу түүнээс дээш хувиар алдах үндсэн эрсдэлийг даатгана.”

4. Мөн журмын 3.1 дэх хэсгийн “зээл олгох үед тухайн зээлийн хэмжээ, даатгалын гэрээг сунгах үед тухайн” гэснийг “даатгалын гэрээ байгуулах” гэж, 3.5 дахь хэсгийн “Даатгагч” гэснийг “Ердийн даатгагч” гэж, 3.8 дахь хэсгийн “Даатгалын” гэснийг “Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын” гэж тус тус өөрчилсүгэй.

5. Мөн журмын 3.7 дахь хэсгийн “Урт хугацааны даатгалын хувьд даатгалын хураамжийг нэг удаа бүрэн төлж болно.” гэснийг хассугай.

6. Мөн журмын 2.2.1, 2.2.2, 3.4.1 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-д даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Төсөл

“Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын 1 дүгээр хавсралт

“..... даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн хувь (жилийн)

БАРЬЦАА ХӨРӨНГИЙН ДААТГАЛ

Үндсэн эрсдэл	Даатгалын хураамжийн хувь
Галын эрсдэл (бүх төрлийн гал түймэр, дэлбэрэлт);	
Сантехникийн эрсдэл;	
Байгалийн эрсдэл (газар хөдлөлтөөс бусад эрсдэлүүд хамаарна);	
Цахилгаан, эрчим хүчний эрсдэл;	
Гуравдагч этгээдээс учруулсан санаатай болон санамсаргүй үйлдэл.	
Нэмэлт эрсдэл	
...	
...	
...	

Тооцооллын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Дундаж хохирлын харьцаа	Цэвэр хураамжийн хувь	Зуучлагчийн шимтгэлийн хувь	Бусад зардлын хувь
Дүн				

Боловсруулсан:

.....

(албан тушаал)

(гарын үсэг)

(овог, нэр)

Хянасан:

Гүйцэтгэх захирал

.....

.....

(гарын үсэг)

(овог, нэр)

(тамга, тэмдэг)

ЗЭЭЛДЭГЧИЙН АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
МЭДҮҮЛГИЙН МАЯГТЫН ЗАГВАР

1. Даатгуулагчийн мэдээлэл

№	Асуулга	Даатгуулагч /үндсэн зээлдэгч/		Даатгуулагч /хамтран зээлдэгч/	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Эцэг (Эх)-ийн нэр:				
2	Нэр:				
3	Регистрийн дугаар:				
4	Хүйс				
5	Боловсрол				
6	Ажил эрхлэлт				
7	Утас				
8	Цахим хаяг				
9	Оршин суугаа хаяг				
ДООРХ ӨВЧНҮҮДЭЭР ОНОШЛОГДОЖ ЭМЧИЛГЭЭ ХИЙЛГЭЖ БАЙСАН ЭСЭХ		Даатгуулагч /үндсэн зээлдэгч/		Даатгуулагч /хамтран зээлдэгч/	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
1	Элэгний В, С, Д вирусын шалтгаантай элэгний үрэвсэл, элэгний хатуурал ба дутагдал				
2	ДОХ-оор өвчилсөн, ХДХВ-ийн халдвар авсан				
3	Судасны цүлхэн, зүрхний титэм судасны нарийсал, зүрхний шигдээс, зүрхний олдмол болон төрөлхийн гажиг, зүрхний дутагдал				
4	Бөөрний түүдгэнцрийн үрэвсэл болон бөөрний дутагдал				
5	Тархины цус харвалт, тархины хавдар, уналт таталт, тархины гэмтлээс гаралтай хүндрэлүүд, саа саажилт				
6	Цусны хүнд өвчнүүд, хүнд цус багадалт, ясны чөмөгний үрэвсэл, тогтолцооны чонон яр, хэрлэг төст үений үрэвсэл, тогтолцоот хатуурал				
7	Чихрийн шижин өвчин бай эрхтэн /зүрх, тархи, бөөр, нүд/-д нөлөөлсөн;				
8	Хорт хавдар өвчин;				
9	Сэтгэцийн болон зан төрхийн өвчин (шизофрени, оюуны хомсдол, тэнэгрэл, солиорол, дэмийрэл)				
10	Хоол боловсруулах эрхтний архаг хүнд өвчнөөр оношлогдож байсан эрхтэн тайруулах эсвэл холбох мэс засал хийлгэж байсан /цөсний хүүдий авах,				

	геморрой, шамбарамын хагалгаа, мухар олгой хамаарахгүй/				
11	Согтууруулах ундаа, мансуурах бодис болон эмэнд донтох өвчин;				
12	Хүнд хэлбэрийн астма, гуурсан хоолойн архаг бөглөрөлтөг үрэвсэл, архаг сүрьеэ, уушги тайруулсан, мэргэжлийн шалтгаант уушгины архаг өвчин				
13	Удамшлын, төрөлхийнөвчин				
14	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоолгосон;				

2. Зээлийн мэдээлэл

Зээлийн дүн буюу үлдэгдэл (төгрөгөөр)

Зээлийн хугацаа (сараар)

3. Зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал

Эрсдэл \үндсэн эрсдэлийг заавал сонгох бөгөөд даатгуулагч нэмэлт эрсдэлийг сонгож болно\

Үндсэн эрсдэл - Нас барах, хөдөлмөрийн чадвараа 70 (дал) буюу түүнээс дээш хувиар алдах эрсдэл

Нэмэлт эрсдэл /нэмэлт эрсдэл тус бүрийг дор дурдах/

.....

.....

Даатгалын компани \зөвхөн нэгийг сонгох\

Урт хугацааны даатгагчийн нэр

Урт хугацааны даатгагчийн нэр

Даатгалын гэрээний хугацаа (жилээр):.....

Даатгалын үнэлгээний нөхцөл \зөвхөн нэгийг сонгох\

Зээлийн хуваарийн дагуу буурах Тогтмол

Хамтын \Joint insurance\ даатгал \зөвхөн нэгийг сонгох\

Тийм Үгүй , үгүй гэж бөглөсөн бол доорх хүснэгтийг бөглөнө үү

	Үндсэн зээлдэгч	Хамтран зээлдэгч
Даатгалын үнэлгээний хувь		

Даатгалын хураамж төлөх нөхцөл \зөвхөн нэгийг сонгох\

Нэг удаа бүрэн төлөх Жилээр Улирлаар Сараар

Даатгалын нөхөн төлбөр олгох нөхцөл \зөвхөн нэгийг сонгох\

Нэг удаа бүрэн төлөх Зээлийн хуваарийн дагуу

4. Даатгалын үндсэн эрсдэлийн хувьд нөхөн төлбөр олгохгүй нөхцөл \унишж танилцана уу\

- Даатгуулагч хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон, эрүүл мэндийнхээ талаар мэдсээр байж нуун дарагдуулсан бөгөөд энэ нь даатгалын тохиолдол болох шалтгаан болсон;
- Даатгуулагчийн өв залгамжлагч нь санаатайгаар даатгалын тохиолдол бий болох нөхцөлийг бүрдүүлсэн нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон;
- Даатгуулагч гэмт хэрэг үйлдэхийг завдсан эсвэл үйлдэж байх үедээ амь насаа алдсан, эрүүл мэнд нь хохирсон;
- Даатгуулагч цэрэг, дайны болон нийтийг хамарсан эмх замбараагүй үйл ажиллагаанд оролцсон.

МЭДҮҮЛЭГ ГАРГАСАН:

Үндсэн зээлдэгч
(гарын үсэг) (овог, нэр)

Хамтран зээлдэгч
(гарын үсэг) (овог, нэр)

Огноо: